НЬЮФОНД ББСБ ХХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Санхүүгийн хураангуй тайлан
2022 оны 12 дугаар сарын 31



Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ньюфонд ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг Ньюфонд ББСБ ХК ("Компани")-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн хураангуй тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Компанийн удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АУОС") 810 буюу "Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн Нягтлан Бодогчид

Доржбатын Мандахбаяр
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 17

A member firm of Ernst & Young Global Limited

НЬЮФОНД ББСБ ХХК
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2022 мян.төг	2021 мян.төг
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	793,182	656,938
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн зардал	(18,963)	(19,685)
Цэвэр хүүгийн орлого	774,219	637,253
Хүлээгдэж буй зээлийн алдагдлын зардал	(3,625)	(2,426)
Зээлийн алдагдлын дараах цэвэр хүүгийн орлого	770,594	634,827
Бусад үйл ажиллагааны орлого	453,332	272,194
Удирдлага болон бусад үйл ажиллагааны зардал	(453,261)	(405,956)
Татварын өмнөх ашиг	770,665	501,065
Орлогын албан татварын зардал	(8,680)	(12,872)
Тайлан жилийн цэвэр ашиг буюу нийт дэлгэрэнгүй орлого	761,985	488,193

Б. Соёлчимэг
Гүйцэтгэх Захирал

Б. Үнэнбат
Санхүүгийн Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 17

Тайлан бэлтгэх үндэслэл. *Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь санхүүгийн байдлын тайлан, ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*

НЬЮФОНД ББСБ ХХК
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2022 MNT'000	2021 MNT'000
Хөрөнгө		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	595,311	1,456,598
Хэрэглэгчдэд олгосон зээл ба урьдчилгаа	6,595,866	5,047,265
Бусад хөрөнгө	99,003	48,379
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,098	3,120
Үндсэн хөрөнгө	37,168	10,281
Ашиглах эрхтэй хөрөнгө	132,709	105,258
Нийт хөрөнгө	7,462,155	6,670,901
Өр төлбөр		
Бусад өр төлбөр	32,775	37,025
Түрээсийн өр төлбөр	134,903	121,911
Орлогын албан татварын өр төлбөр	21,561	1,034
Нийт өр төлбөр	189,239	159,970
Эздийн өмч		
Хувьцаат капитал	4,729,521	4,729,521
Хуримтлагдсан ашиг	2,543,395	1,781,410
Нийт эздийн өмч	7,272,916	6,510,931
Нийт өр төлбөр болон эздийн өмч	7,462,155	6,670,901

Б. Соёлчимэг
Гүйцэтгэх Захирал

Б. Үнэнбат
Санхүүгийн Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 17

Тайлан бэлтгэх үндэслэл. *Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь санхүүгийн байдлын тайлан, ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*